

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 10-р сарын 10-ны байдлаар


2018 оны 10-р сарын 10-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 2.1 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.3 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 10-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 3.1, үхрийн ястай махны үнэ 1.2 хувь, үхрийн цул махны үнэ 1.6 хувь, адууны ястай махны үнэ 5.0 хувь, ямааны ястай махны үнэ 3.2 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.8 хувь, үхрийн ястай махны үнэ 0.3 хувь, үхрийн цул махны үнэ 0.5 хувь, адууны ястай махны үнэ 2.1 хувиар буурсан бол, ямааны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 10-р сарын 10-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6210 төгрөг, үхрийн /ястай/ мах 7690 төгрөг, үхрийн цул мах 9330 төгрөг, адууны /ястай/ мах 5775 төгрөг, ямааны /ястай/ мах 4550 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг



Гурилын үнэ: 2018 оны 10-р сарын 10-ны гурилын үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 10-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй харин элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос 2 хувиар нэмэгдсэн байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 10-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 12.9 хувь, луувангийн үнэ 19.4 хувь, байцааны үнэ 7.9 хувь, хүрэн манжингын үнэ 7.8 хувиар буурсан бол, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоноогоос луувангийн үнэ 1.3 хувь, байцаа 1.3 хувь, хүрэн манжингийн үнэ 5.7 хувиар буурсан бол төмс болон сонгины дундаж үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 10-р сарын 10-ны байдлаар сүүний үнийг өмнөх сартай болон өмнөх 7 хоногтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.4 хувиар буурсан бол бусад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ болон цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар
2018 оны 10-р сарын 10**